АЖЛЫН БАЙР (АЛБАН ТУШААЛ)-НЫ ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

☑ Байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоонд өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн нэр, огноо: "ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны А/49 дүгээр тушаал

Албан тушаалын тодорхойлолтын дугаар: "ИНҮТ" ТӨХКК - 89

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: 2025.03.14 А/124

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
"Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК	Агаарын навигацийн үйлчилгээний газар
Албан тушаалын нэр:	**Албан тушаалын ангилал, зэрэглэл:**
Агаарын навигацийн техникийн үйлчилгээ хариуцсан технологич мэргэжилтэн /Ажиглалт/	
Ажлын цаг:	**Ажлын байрны албан ёсны байршил:**
Ердийн	ХУД-ийн 21-р хороо, "ИНҮТ" ТӨХХК
Хөдөлмөрийн нөхцөл:	**Онцгой нөхцөл:**
Хэвийн	

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Агаарын навигацийн үйлчилгээний ажиглалтын төхөөрөмжийн технологи үйл ажиллагааны баримт бичгийг ИНД-171-ийн хүрээнд боловсруулах, инженерингийн тооцоо судалгаа, шинэ техник, технологийн судалгааг гүйцэтгэх, ажиглалтын тоног төхөөрөмжүүдийн шинэчлэлт болон бэлэн байдлыг хангахтай холбоотой техникийн тодорхойлолтыг боловсруулах, гарсан гэмтэл дутагдалд дүгнэлт, зөвлөмж гаргах, залруулах арга хэмжээг төлөвлөх, сэлбэг хангалтын оновчтой аргачлалын судалгаа хийж дүгнэлт боловсруулах, ажиглалтын тоног төхөөрөмж болон ажиглалтын инженер техникийн ажилтнуудын мэргэжлийн үнэмлэхний бүртгэлийг гүйцэтгэх, хяналт тавих

Албан тушаалын зорилт:

1. Агаарын навигацийн үйлчилгээний ажиглалтын тоног төхөөрөмжийн технологи үйл ажиллагааны баримт бичгийг боловсруулах, үйл ажиллагааны технологийг сайжруулах;
2. Ажиглалтын тоног төхөөрөмжийн ашиглалтын болон технологи үйл ажиллагааны чиглэлээр инженерийн тооцоо судалгаа хийх, техникийн тодорхойлолт, шаардлагыг боловсруулах, техникийн шинэчлэлтэй уялдуулан дэвшилтэт техник, технологийн судалгааг хийх, санал дүгнэлт боловсруулах;
3. Ажиглалтын тоног төхөөрөмж, байгууламжийн бэлэн байдал, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, зөрчил дутагдлыг арилгуулах, аюулгүй байдлыг хангуулах;
4. Ажиглалтын тоног төхөөрөмжийн гэмтэл дутагдалд судалгааг хийж дүгнэлт, зөвлөмж гаргах, залруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжилтийг хангуулах, Аюулгүй байдал, чанарын нэгдсэн удирдлагын тогтолцооны хэрэгжилтийг хангуулах;
5. Инженер техникийн ажилтнуудын мэргэжлийн үнэмлэхний бүртгэлийг хянах, шалгах, шинээр олгох;
6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх;

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр

			Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1 Ажиглалтын төхөөрөмжийн техник үйлчилгээ, хэмжилт тохиргоо, үйл ажиллагааны баримт бичгийн боловсруулалтыг хийх; 1.2 Ажиглалтын тоног төхөөрөмжийг суурилуулах, хэмжилт тохиргоог гүйцэтгэх үйл ажиллагааны горимыг тогтоох, сайжруулалт хийх, зааврыг гаргах, холболтын зураг, техникийн шаардлагад өөрчлөлт оруулах; 1.3 Байгууламж, тоног төхөөрөмжийг түр ажиллуулж туршилт хийх ажлын зорилго, хугацаа, төлөвлөгөөг боловсруулах, дүгнэлт гаргах; 1.4 Агаарын навигацийн техникийн үйлчилгээний байгууллагын ерөнхий заавар болон дагалдах журмуудыг ИНД-171 дүрмийн хүрээнд боловсруулах	Агаарын навигацийн үйлчилгээний байгууламж, тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай үйл ажиллагааг хангахад шаардлагатай хөтөлбөр, төлөвлөгөө, хуваарь батлагдсан байна.	Г Т Г Г
2 дугаар зорилтын хүрээнд	2.1 Ажиглалтын тоног төхөөрөмж, байгууламж, тоног төхөөрөмжүүдийн техник ашиглалтын заавар (ТАЗ)-г хянах, өөрчлөх, баталгаажуулах; 2.2 Ажиглалтын тоног төхөөрөмж, байгууламж, тоног төхөөрөмжүүдийн ашиглалт, үр ашиг, найдваржилттай уялдуулан шинэчлэлтийн чиглэлээр инженерийн тооцоо судалгаа боловсруулах; 2.3 Техникийн шинэчлэлт болон ажиглалтын тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангахтай холбоотой сэлбэг материалын техникийн даалгавар, техникийн тодорхойлолтыг боловсруулах; 2.4 Ажиглалтын чиглэлээрх худалдан авах ажиллагаанд гишүүнээр оролцох; 2.5 Ажиглалтын тоног төхөөрөмжийн техникийн шинжилгээ, судалгааг хийж, шинэ техник технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх санал боловсруулах, шинээр зохион бүтээх, угсрах болон өргөтгөл, шинэчлэлт, засвар хийх техник, байгууламж, тоног төхөөрөмжийн техник эдийн засгийн тооцоог хийх, суурилуулалтын зураг төслийг боловсруулах, зохиох, инженер техникийн ажилтнуудын зохиосон төслийг шалгах, ажлын явцыг хянаж дүгнэлт хийх ба магадлан итгэмжлэлийг гүйцэтгэх; 2.6 Ажиглалтын тоног төхөөрөмжид хамаарах ашиглалтын болон технологийн үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэхтэй холбоотой инженерингийн тооцоо, тооцоолол, судалгаа хийх, боловсруулах, батлуулах, өөрчлөлт оруулах; 2.7. Олон улсын агаарын навигацийн үйлчилгээний техникийн хөгжлийн чиг хандлага, технологийн өөрчлөлтөд судалгаа дүгнэлт хийх, холбогдох зөвлөмжийг гаргах, техникийн тодорхойлолт, шаардлагад тусгаж бичиг баримтыг боловсруулах;	ИНД-171 дүрмийн хүрээнд батлагдсан Ерөнхий заавартай, албаны бүх үйл ажиллагааг хамарсан, ашиглахад хялбар, ойлгомжтой технологийн журам, заавартай, албаны хэмжээнд мөрдөн ажиллаж хэвшсэн байна.	Г Г Г Г Г Г Г

3 дугаар зорилтын хүрээнд	3.1 Техникийн үйл ажиллагааг удирдах, өөрөө биечлэн гүйцэтгэх, гүйцэтгэж буй инженер техникийн ажилтнуудын ажлыг хянаж зөвлөх ба дээрх ажлын гүйцэтгэлийн тайлан, дүгнэлт, техникийн акт, баримт бичиг, зураг төсөл зэрэгт гарын үсэг зурах, удирдан хийлгэсэн, зөвлөж, хянаж баталгаажуулсан ажлын үр дүн, чанарыг бүрэн хариуцах; 3.2 Ажиглалтын тоног төхөөрөмжийн шинэчлэлт, сайжруулалтын ажлын гүйцэтгэлд хяналт тавих, тайлагнах; 3.3 Байгууламжид хамаарах ашиглалтын болон технологийн үйл ажиллагааг судалгаа, тооцооллын дагуу сайжруулах буюу төлөвлөлт хийж хэрэгжүүлэлтэд хяналт тавих; Төлөвлөлт нь: • Ажиглалтын тоног төхөөрөмжийг шинэчлэх, сайжруулах төлөвлөлт • Ажиглалтын тоног төхөөрөмжид улирал, жилд хийгдэх техник үйлчилгээний төлөвлөлт, • Нөөцийн төлөвлөлт (нөөцөд хүн, сэлбэг, журам заавар багтана.) 3.4 Ажиглалтын тоног төхөөрөмжийн өдөр тутмын бэлэн байдлын мэдээллийг авч нэгтгэн, танилцуулах; 3.5 НМЭ-ээр зарлагдсан мэдээлэлд нэмэлт өөрчлөлт оруулах, дүн шинжилгээ хийх; 3.6 Харилцан ажиллагааны зохицуулалтын журмуудыг боловсруулах, хэрэгжилтийг хангах; 3.7 Онцгой нөхцөл үүссэн үед удирдлагыг мэдээллээр хангах, бэлэн байдал, аюулгүй байдлыг хангуулах;	Иргэний нисэхийн салбарт төр засгаас баримталж байгаа бодлого, олон улсын иргэний нисэхийн ажиглалтын үйлчилгээний хөгжлийн чиг хандлагад нийцсэн, Монгол Улсын хууль эрх зүйн актуудыг бүрэн хангасан, орчин үеийн тэргүүлэх технологид тулгуурласан, техникийн хөгжилд үндэслэсэн байна.	Г Г, Х, Т Г, Х Г Г Г Г
4 дүгээр зорилтын хүрээнд	4.1. Ажиглалтын тоног төхөөрөмжүүдийн гэмтэл дутагдалд судалгааг хийх, дүгнэлт гаргах, гэмтэл саатал хоорондын хугацаа (MTBF), гэмтлийг засварлах хугацааг (MTTR) бууруулахад шаардагдах арга члал, зөвлөмжийг боловсруулах; 4.2. Гэмтэл дутагдал гарсан шалтгаанд үнэлгээ дүгнэлт хийх, дахин давтагдаж гарах гэмтлээс урьдчилан сэргийлэх талаар ахлах технологич мэргэжилтэнд танилцуулах; 4.3. Ажиглалтын тоног төхөөрөмжүүдийг ашиглалтад бэлэн байлгах үүрэг хариуцлага хүлээсэн ажилтны мэргэжил, мэргэшил, дадлага туршлага, ур чадварыг дээшлүүлэх талаар санал боловсруулах, Мэргэжлийн сургалт, шалгалтын комисст хүргүүлэх; 4.4. Ажиглалтын тоног төхөөрөмжүүдэд гарсан гэмтэл дутагдал, зарцуулсан сэлбэг материалын тоо хэмжээнд үндэслэн хэвийн найдвартай ажиллагааг хангахад шаардлагатай сэлбэгийн тоо хэмжээг тодорхойлж ахлах технологич мэргэжилтэнд танилцуулах; 4.5. Шаардлагатай тохиолдолд нийлүүлэгдсэн сэлбэг хэрэгсэл, бараа материалын техникийн шаардлага хангасан байдал, чанарын үзүүлэлтэд дүгнэлт гаргах, 4.6. Байгууламжийн хэвийн ажиллагааг хангах сэлбэгийн оновчтой тоо, хэмжээг тогтоох;	Одоогийн ажиллаж буй систем, төхөөрөмжүүдэд инженерийн тооцоо, судалгааг явуулах, гэмтэл, дутагдлын нарийвчилсан судалгаа, анализ дээр үндэслэсэн байна.	Г, Х Г, Х Г, Х Г, Х Г, Х Г, Х

	4.7. Сэлбэг хангалтын оновчтой байдал, зарцуулалтыг улирал тутам судалж ахлах технологич мэргэжилтэнд танилцуулах; 4.8. Байгууламжийн саатал, дутагдлын судалгааг улирал тутам гүйцэтгэж ахлах технологич мэргэжилтэнд танилцуулах; 4.9 Байгууламжийн гэмтэл дутагдлыг шинжлэн шалгах, нөлөөлсөн хүчин зүйлсийг илрүүлэх, тухайн төрлийн гэмтэл дутагдлыг давтан гаргахгүй байх арга хэмжээг шуурхай, оновчтой зохион байгуулж, хэрэгжүүлэх заавар чиглэлээр хангах; 4.10 Залруулах болон эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг хангуулах, хэрэгжилтийг тайлагнах; 4.11 Дотоод болон гадаад аудитаас илэрсэн үл тохирлыг залруулах, ИНЕГ-ын байцаагчийн дүгнэлт, шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөх, хянах;		Г, Х Г, Х Г, Х Г, Х Г, Х
5 дугаар зорилтын хүрээнд	5.1 Байгууламжийг ашиглалтад бэлэн байлгах үүрэг хариуцлага хүлээсэн ажилтны мэргэжил, мэргэшил, дадлага туршлага, ур чадвар, түүнд олгогдсон ажиллах эрхийн талаар бүртгэлийг гүйцэтгэх; 5.2 Ажиглалтын тоног төхөөрөмжийн байршил, хаягийн жагсаалт, тоног төхөөрөмжийг баталгаажуулах бүртгэлийг хянах;	Нөөцийн бүртгэл, хяналт хийгдсэн байна.	Г Г
6 дугаар зорилтын хүрээнд	6.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт, дүрэм, технологийн горимыг чанд мөрдөх; 6.2 Ажил олгогчийн зүгээс хууль тогтоомжийн хүрээнд нийцүүлэн тавьсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг биелүүлж ажиллах, 6.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан байх, аюулгүй ажиллагааны зааварчилга авсан байх; 6.4 Ажил, үүргээ осол эндэгдэлгүй гүйцэтгэх арга барил, мэргэжлийн ур чадвар эзэмших, осол гэмтэл, хурц хордлогоос сэргийлэх, болзошгүй аюул, ослын үед анхны тусламж үзүүлэх чадвар эзэмшсэн байх; 6.5 Осолд дөхсөн тохиолдлыг бүртгэх болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, үйлдвэрлэлийн орчинд учирч болох аюулыг илрүүлэх, тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах талаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтанд мэдээлэх, хамтран ажиллах;	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн байна	Г Г Г Г Г, Т
Ажлын байрны зорилгын хүрээнд явуулах бусад үйл ажиллагаа	• Удирдлагын өгсөн чиглэлээр санал боловсруулах, удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангах, ажлын явцыг удирдлагад танилцуулах; • Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хэрэгжүүлж ажиллах, гүйцэтгэлийг эргэн тайлагнах; • Удирдлагын цохолтоор ирсэн албан бичгүүдийг хууль, журмын дагуу Монгол хэлний утга зүй, найруулга, дүрмийн алдаагүй, үнэн зөв боловсруулах;	Удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгавар, ажлын байрны хүрээнд явагдсан бусад үйл ажиллагаа бүрэн хангагдсан байна	Г Г Г

	• Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах, гүйцэтгэлийн тайланг гаргаж, тогтоосон хугацаанд үнэлүүлэх; • Хөдөлмөрийн дотоод журамд тусгагдсан байгууллагын соёл, эрхэмлэх үнэт зүйлс, ажилтны манлайлал, ёс зүйн хэм хэмжээг мөрдлөг болгон ажиллах; • Мэдлэг ур чадвараа дээшлүүлэх талаар идэвх чармайлт, санал, санаачилга гарган ажиллах; • Компанийн "Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт"-ын дагуу баримт, материалыг архивын нэгж бүрдүүлэн бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөх;		Г Г Г Г

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Дээд боловсролтой, бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй	
Мэргэжил	Радио холбоо /071408/ Радионавигаци Электроникийн инженер /071401/	
Мэргэшил	Монгол Улсын мэргэшсэн инженер болон түүнээс дээш зэрэгтэй бол давуу тал болно	
Туршлага	Агаарын навигацийн үйлчилгээний салбарт 8-аас доошгүй жил ажилласан, үүнээс агаарын навигацийн инженерээр 5-оос доошгүй жил ажилласан байх	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	• Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; • Судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй байх. • Шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх. • Дүн шинжилгээ хийх
	Асуудал шийдвэрлэх	• Оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах; • Албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд аливаа асуудлыг хууль болон ёс зүйг сахиж, ашиг сонирхлоос аливаа зөрчлөөс сэргийлж, авлига, хүнд суртлаас ангид ажиллах • Асуудлыг цогцоор нь шийдвэрлэх чадвар • Төлөвлөлт болон зохион байгуулах чадвар
	Багаар ажиллах чадвар	• Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; • Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; • Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах; • Өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх; • Зааварлан удирдах чадвартай байх;
	Бусад	• Албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; • Монгол хэл, бичгийн дүрмийн дагуу үг үсгийн болон утга найруулгын алдаагүй бичих; • Монгол бичгийн анхан шатны мэдлэгтэй байх; • Компьютерын өргөн хэрэглээний программуудыг ашиглаж чаддаг байх; • Албан тушаалын чиг үүрэгт хамаарах асуудлаар англи хэл, бусад гадаад хэлээр мэдээллийн эх сурвалж ашиглах; • Ачаалал даах чадвартай байх; • Хувийн зохион байгуулалт, цаг ашиглалтын менежмент сайтай байх;

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Агаарын навигацийн менежмент, технологи үйл ажиллагаа хариуцсан менежер, Агаарын навигацийн техникийн үйлчилгээ хариуцсан ахлах технологич мэргэжилтэн	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект: - Иргэний нисэхийн ерөнхий газар - Компанийн харьяа салбар нэгжүүд - Иргэний нисэхийн салбарын бусад байгууллагууд - Агаарын тээвэрлэгч байгууллагууд

	- Хамтран ажиллах гэрээ бүхий гадаад, дотоод байгууллагууд - Ажил хэргийн хүрээнд харилцах бусад байгууллага, иргэд

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: ЗАХИРГАА, САНХҮҮ ХАРИУЦСАН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР Н.ЗОЛЖАРГАЛ 2025 оны 03 дугаар сарын 14-ны өдөр	Байгууллагын нэр: “ИНҮТ” ТӨХХК Шийдвэрийн огноо: 2025.02.18 Дугаар: А/49

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: “ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨХХК

Шийдвэрийн огноо: 2025 оны 03 дугаар сарын 14 өдөр

Дугаар: А/124
(тамга/тэмдэг)

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ТӨХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ОТГОНСҮХ

2025 оны 03 дугаар сарын 14-ны өдөр